



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/103/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит
ХХК
Утас: 70110090
Цахим хаяг: audit@azure.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Төлбөрийн акт.....	8
3.2 Албан шаардлага	9
3.3 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.16 № 40
танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.АЛТАНСҮХ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, дотуур байрны хүүхдийн хоолны нормыг хэтрүүлэн зарцуулсан, кабинетын хэрэглэгдэхүүнийг багцалж 1 ширхгээр бүртгэсэн зэрэг 38,594.4 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 41.7 хувиар их байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.1, 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6-д заасан заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын засгийн газрын Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 280,457.9 мянган төгрөгөөр өссөн

4826050134

байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	65,832,850.65	26,765,179.13		
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	65,832,850.65	26,765,179.13		
31210	Төгрөг	65,832,850.65	26,765,179.13		
31211	Төрийн сангийн харилцах	59,807,156.24	26,765,179.13		
31218	Ахмадын сангийн харилцах	6,025,694.41	-		
33	АВЛАГА	4,718,886.00	4,676,455.28		
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,482,691.00	2,169,965.87		
33101	Цалингийн авлага	2,482,691.00	1,872,359.00		
33102	НДШ-ийн авлага	-	272,956.87		
33103	ХАОАТ-ын авлага	-	24,650.00		
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	2,466,394.41		
33500	Бусад авлага	2,236,195.00	40,095.00		
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,236,195.00	40,095.00		
35	БАРАА МАТЕРИАЛ	118,587,579.44	120,507,955.19		
35100	Түүхий эд материал	52,635,363.58	65,589,363.58		
35110	Тусгай зориулалттай материал	52,635,363.58	65,589,363.58		
35400	Хангамжийн материал	65,952,215.86	54,918,591.61		
35410	Бичиг хэргийн материал	10,984,220.00	8,604,120.00		
35420	Аж ахуйн материал	49,153,171.86	35,991,051.61		
35460	Хүнсний материал	5,814,824.00	10,323,420.00		
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	189,139,316.09	151,949,589.60		
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,453,835,700.24	3,449,699,895.14		
39200	Биет хөрөнгө	3,411,540,195.20	3,408,759,895.74		
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,312,423,085.25	3,312,423,085.25		
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(300,468,122.05)	(362,598,982.81)		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,290,000.00	70,290,000.00		
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(57,134,000.12)	(63,712,000.16)		
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	422,813,212.95	392,761,963.40		
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(223,195,972.16)	(164,900,765.04)		
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	297,522,141.00	287,547,184.30		
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(158,833,381.19)	(98,543,685.94)		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	11,000,000.00	11,000,000.00		
39217	Номын фонд	37,123,231.52	24,493,096.74		
39300	Биет бус хөрөнгө	42,295,505.04	40,939,999.40		
39301	Програм хангамж	9,379,420.00	9,379,420.00		
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(5,017,914.96)	(7,199,420.60)		
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
39303	Бусад биет бус хөрөнгө	37,934,000.00	38,760,000.00		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	3,453,835,700.24	3,449,699,895.14		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	3,642,975,016.33	3,601,649,484.74		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	58,354,917.35	34,661,323.00		
41300	Өглөг	58,354,917.35	34,661,323.00		
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,441,730.82	39,336.00		
41311	Цалингийн өглөг	689,905.82	39,336.00		
41312	НДШ-ийн өглөг	1,149,958.00	-		
41313	ХАОАТ-ын өглөг	601,867.00	-		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	55,863,186.53	34,621,987.00		
413201	Бичиг хэргийн өглөг	-	653,000.00		
413203	Түлш халаалтын өглөг	18,785,509.53	79,860.00		
413205	Тээвэр, шатахууны өглөг	119,250.00	1,484,000.00		
413208	Хоолны өглөг	279,500.00	-		
413213	Бусад зардлын өглөг	36,678,927.00	32,405,127.00		
41360	Бусад өглөг	50,000.00	-		
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	50,000.00	-		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-		
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	58,354,917.35	34,661,323.00		

51	Засгийн газрын хувь оролцоо	3,584,620,098.98	3,566,988,161.74
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	544,254,424.94	544,254,424.94
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	544,254,424.94	544,254,424.94
51200	Хуримтлагдсан үр дүн	2,689,723,208.42	2,672,091,271.18
51210	Өмнөх үеийн үр дүн	2,444,221,599.03	2,689,723,208.42
51220	Тайлант үеийн үр дүн	245,501,609.39	(17,631,937.24)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	350,642,465.62	350,642,465.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	3,584,620,098.98	3,566,988,161.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	3,642,975,016.33	3,601,649,484.74

2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
11	ТАТВАРЫН ОРЛОГО		
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,206,249,400.00	2,511,002,700.00
1310	Улсын төсвөөс	1,916,652,200.00	2,182,637,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,916,652,200.00	2,182,637,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,597,200.00	328,365,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,597,200.00	328,365,000.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	360,659,582.20	210,547,536.00
1200	Нийтлэг татварын бус орлого	360,659,582.20	210,547,536.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	314,754,969.20	13,774,230.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	3,337,700.00	2,625,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	30,689,245.20	11,149,230.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	280,728,024.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	36,457,690.00	163,898,286.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	9,446,923.00	32,875,020.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,566,908,982.20	2,721,550,236.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,319,637,132.40	2,723,721,058.72
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,260,277,812.23	2,639,437,184.85
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,513,339,064.00	1,793,797,038.00
210101	Үндсэн цалин	942,015,742.00	989,908,174.00
210102	Нэмэгдэл	433,745,882.00	646,247,891.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	49,409,800.00
210104	Урамшуулал	137,577,440.00	108,231,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,008,059.22	214,527,009.82
210201	Тэтгэврийн даатгал	124,267,999.22	146,613,840.95
210202	Тэтгэмжийн даатгал	14,867,156.00	17,917,445.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,264,522.00	9,025,927.53
210204	Ажилгүйдлийн даатгал	6,159,101.00	8,203,203.52
210205	Эрүүл мэндийн даатгал	28,449,281.00	32,766,592.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	279,656,729.83	284,033,306.60
210301	Гэрэл, цахилгаан	19,007,779.83	24,342,956.60
210302	Түлш, халаалт	259,070,350.00	259,070,350.00
210303	Цэвэр, бохир ус	1,578,600.00	620,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,101,950.00	42,562,455.25
210401	Бичиг хэрэг	4,299,610.00	6,121,125.00
210402	Тээвэр, шатахуун	4,390,950.00	5,823,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,411,390.00	10,606,810.00
210408	Бараа материал актласны зардал	-	17,835,820.25
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	2,175,000.00
2105	Нормативт зардал	36,316,666.00	45,996,024.00
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	269,600.00	1,042,860.00
210502	Хоол, хүнс	36,047,066.00	44,953,164.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,657,750.00	20,541,160.00
210604	Урсгал засвар	7,657,750.00	20,541,160.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,253,519.94	22,368,300.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,895,000.00	2,625,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,411,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,358,519.94	18,332,100.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,944,073.24	215,611,890.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,707,050.40	29,258,289.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	6,218,102.00	7,370,260.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	147,018,920.84	178,983,341.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,359,320.17	84,283,873.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,293,000.00	74,967,830.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,399,610.00	61,570,630.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,893,390.00	13,397,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,066,320.17	9,316,043.87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,066,320.17	9,316,043.87
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,319,637,132.40	2,723,721,058.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	247,271,849.80	(2,170,822.72)
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-	-
24	Гадаад зээлийн үндсэн төлбөр	-	-
25	Гадаад валютын ханшийн зөрүү	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	1,130,334.59	15,461,114.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,130,334.59	15,461,114.52
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	1,130,334.59	15,461,114.52
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	246,141,515.21	(17,631,937.24)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,206,249,400.00	2,511,002,700.00
1310	Улсын төсвөөс	1,916,652,200.00	2,182,637,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,916,652,200.00	2,182,637,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,597,200.00	328,365,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,597,200.00	328,365,000.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	32,374,250.20	16,186,830.00
1200	Нийтлэг татварын бус орлого	32,374,250.20	16,186,830.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,374,250.20	16,186,830.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	3,337,700.00	3,175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	29,036,550.20	13,011,830.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,238,623,650.20	2,527,189,530.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,188,393,184.56	2,539,846,836.52
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,131,018,264.39	2,453,490,698.24
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,513,980,126.00	1,795,028,484.82
210101	Үндсэн цалин	942,656,804.00	991,139,620.82
210102	Нэмэгдэл	433,745,882.00	646,247,891.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	49,409,800.00
210104	Урамшуулал	137,577,440.00	108,231,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,547,863.22	215,935,232.69
210201	Тэтгэврийн даатгал	124,267,999.22	148,022,063.82
210202	Тэтгэмжийн даатгал	14,867,156.00	17,917,445.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,264,522.00	9,025,927.53
210204	Ажилгүйдлийн даатгал	6,159,101.00	8,203,203.52
210205	Эрүүл мэндийн даатгал	27,989,085.00	32,766,592.54

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	279,656,729.83	302,738,956.13
210301	Гэрэл, цахилгаан	19,007,779.83	24,342,956.60
210302	Түлш, халаалт	259,070,350.00	277,775,999.53
210303	Цэвэр, бохир ус	1,578,600.00	620,000.00
2105	Нормативт зардал	36,598,600.00	41,123,050.00
210502	Хоол, хүнс	36,598,600.00	41,123,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,368,350.00	17,989,000.00
210604	Урсгал засвар	6,368,350.00	17,989,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,784,492.94	26,642,100.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,895,000.00	2,625,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,889,492.94	24,017,100.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,082,102.40	54,033,874.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,988,550.40	45,671,014.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	11,093,552.00	8,362,860.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,374,920.17	86,356,138.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,308,600.00	74,573,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,415,210.00	61,176,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,893,390.00	13,397,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,066,320.17	9,316,043.87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,066,320.17	9,316,043.87
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,466,394.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,466,394.41
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	2,188,393,184.56	2,539,846,836.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	50,230,465.64	(12,657,306.52)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,361,150.00	26,410,365.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	40,361,150.00	26,410,365.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	40,361,150.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,361,150.00	26,410,365.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	40,361,150.00	26,410,365.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(40,361,150.00)	(26,410,365.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	9,869,315.64	(39,067,671.52)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,963,535.01	65,832,850.65
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	65,832,850.65	26,765,179.13

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,439,406,575.60	3,334,303,466.16
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,815,023.43	4,815,023.43
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,444,221,599.03	3,339,118,489.59
9	Тайлант үеийн үр дүн	-	-	246,141,515.21	246,141,515.21
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,689,723,208.42	3,584,620,098.98

13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,689,723,208.42	3,584,620,098.98
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,631,937.24)	(17,631,937.24)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,672,091,271.18	3,566,988,161.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	/төгрөгөөр/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Тагаас, санхүүжилтийн орлого	2,587,423,000.00	2,511,002,700.00	76,420,300.00
Улсын төсвөөс	2,201,429,700.00	2,182,637,700.00	18,792,000.00
Орон нутгийн төсвөөс	328,365,000.00	328,365,000.00	-
Тусламжийн орлого	57,628,300.00	-	57,628,300.00
Бараа, үйлчилгээний орлого	-	-	-
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	23,786,120.00	16,186,830.00	7,599,290.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,611,209,120.00	2,527,189,530.00	76,420,300.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	2,038,432,200.00	2,010,963,717.51	27,468,482.49
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,811,939,800.00	1,795,028,484.82	16,911,315.18
Цалин	1,811,939,800.00	1,795,028,484.82	16,911,315.18
Нийгмийн хамгааллын шимтгэл	226,492,400.00	215,935,232.69	10,557,167.31
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	226,492,400.00	215,935,232.69	10,557,167.31
Бараа, үйлчилгээний урсгал зардал	572,776,920.00	549,267,789.60	23,509,130.40
Тогтмол зардал	311,876,000.00	302,738,956.13	9,137,043.87
Гэрэл цахилгааны зардал	29,000,000.00	24,342,956.60	4,657,043.40
Түлш, халаалтын зардал	277,776,000.00	277,775,999.53	0.47
Цэвэр, бохир усны зардал	5,100,000.00	620,000.00	4,480,000.00
Хоол	48,228,700.00	41,123,050.00	7,105,650.00
Бусад бараа үйлчилгээний зардал	80,796,800.00	68,522,079.00	12,274,721.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	8,363,600.00	8,362,860.00	740.00
Урсгал засварын зардал	17,989,000.00	17,989,000.00	
Бусад зардал	27,917,620.00	39,958,144.47	(8,040,524.47)
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	13,569,700.00	13,397,200.00	172,500.00
Бусад /үдийн цай/	64,035,500.00	61,176,500.00	2,859,000.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,611,209,120.00	2,560,231,507.11	50,977,612.89
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	59,807,156.24	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	26,765,179.13	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38,594.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 157.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3,216.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 35,219.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж тус тус хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Төсөв захирагч байгууллагын албан хаагчдад гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгох тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулж 157.8 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т (*Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, ... зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно*) гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль зөрчиж олгосон урамшууллыг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон

3.2 Албан шаардлага

3.2.1 Тайлант хугацааны эцэст 1,912.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дүгээр зүйл 12.2-т "*Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ*", 12.2.1-т "*жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө*" 20 дугаар зүйлийн 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*) заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.2.2 Сургуулийн хүнсний материалын тайланд тусгасан хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, Засгийн газрын тогтоолд зааснаас 1,304.3 мянган төгрөгийг илүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6-д (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), Засгийн газрын 2025 оны 254 дугаар тогтоолын 2-д (*Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 (зургаан мянга гурван зуу) төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000 (зургаан мянга) төгрөгөөр тус тус тогтоосугай*) гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний материалын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэх, хоолны зардлыг батлагдсан нормын дагуу тооцож зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх; албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

3.3.1 Бараа материалын түүвэр тооллого хийхэд 8865 кодтой кабинетын хэрэглэгдэхүүнийг багцалж 1 ширхгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 20 дугаар зүйлийн 20.2.3 (*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*)

Шийдвэрлэсэн нь: Багцалж 1 ширхгээр бүртгэсэн кабинетын хэрэглэгдэхүүнийг задалж тус бүрээр бүртгэх зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн 100.0 хувийг залруулагдаагүй зөрчил эзэлж байна. Нийт 38,594.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 38,594.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 11,357.2 мянган төгрөгөөр их байгаа тул “ХЯЗГААРЛАЛТАЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсөв захирагч байгууллагын албан хаагчдад гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгох тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулж урамшуулал олгосон байна.	1	157.8	1	157.8						
Тайлант хугацааны эцсээрх авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	1,912.5	-	-	1	1,912.5	-	-	-	-
Сургуулийн хүнсний материалын тайлангаас зарлагын баримт, хоолны ордерыг тулгаж шалгахад хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, Засгийн газрын тогтоолд зааснаа илүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.	1	1,304.3	-	-	1	1,304.3	-	-	-	-
Бараа материалын түүвэр тооллого хийхэд 8865 кодтой кабинетын хэрэглэгдэхүүнийг багцалж 1 ширхгээр бүртгэсэн байна.	1	35,219.8	-	-	-	-	1	35,219.8	-	-
Дүн	4	38,594.4	1	157.8	2	3,216.8	1	35,219.8	-	-